

ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	<p>Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (уялдаа, холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)</p> <p>Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл</p> <p>2015 оны 1 дүгээр сарын 16-нд байгуулагдсан</p>	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилго</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах</p>
2	<p>Санхүүжилтийн эх үүсвэр</p> <p>Улсын төсөв</p>	<p>Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж</p> <p>Улсын төсөв</p>
3	<p>Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/ Жайка олон улсын байгууллага / 5 жил /</p>	<p>Үндсэн хэрэгжүүлэх байгууллага</p> <p>Жайка төслийн нэгж, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, загвар аймаг болох Булган аймаг, Орхон аймгийн БОЭТ, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газрууд</p>
4	<p>Төсөл хөтөлбөрийн зорилтууд</p>	<p>Зорилт 1.</p> <p>Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах чадавхи сайжрах</p> <p>Зорилт 2.</p> <p>Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр сайжрах</p> <p>Зорилт 3.</p>

				Загвар аймагт эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо сайжрах		
5	<i>Зардал</i>	<i>Төсөв</i> (<i>нийт шаардагдах зардал</i>)	<i>Төсөв</i> 90,405,000	<i>Гүйцэтгэл</i> 88,785,062	<i>Хувь</i> 98%	
		<i>Үүнд:</i>				
		<i>Багц 1 Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх</i>	<i>48,000,000</i>	<i>40,111,462</i>		
		<i>Багц 2 Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ сургалт /AALS/</i>	<i>33,960,000</i>	<i>43,500,600</i>		
		<i>Багц 3 Хүүхдийн амилуулах суурь тусламж /PBLs/</i>	<i>8,445,000</i>	<i>5,173,000</i>		
6	<i>Төсөл хөтөлбөрийн зорилт:</i>			<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ</i>		
	<i>1-р зорилтын хүрээнд:</i> Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалттай холбоотой явцын хяналт, үнэлгээний механизмыг сайжруулан бэхжүүлэх			<ul style="list-style-type: none"> - ЖАЙКА байгууллагын “Анхан ба хоёрдах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн багтай хамтран Сургалт эрхлэх байгууллагын явцын үнэлгээний шалгуур, тайлан бичих загварыг боловсруулж, ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтнээр болон төвийн холбогдох албан тушаалтнуудаар хянуулан, төвийн Ерөнхий захирлын 2019.03.29-ний өдрийн А/32 дугаар тушаалаар баталгаажуулсан. - Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын явцын үнэлгээ хийх үнэлээч бэлтгэх сургалт зохион байгуулж, 5 мэргэжилтнийг бэлтгэсэн. - Ерөнхий захирлын удирдамжийн дагуу Сургалт эрхлэх 12 байгууллагын сургалтын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Улсын хоёрдугаар төв эмнэлэг, - Улсын гуравдугаар төв эмнэлэг, - Гэмтэл согог судлалын үндэсний төв, - Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн, - Эмгэг судлалын үндэсний төв, - Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв - Зоонозын өвчин судлалын үндэсний төв 		

	<ul style="list-style-type: none"> - Цэргийн төв эмнэлэг - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв - Нийслэлийн Амгалан амаржих газар - ЭМЖЖ эмнэлэг - Ачтан эмнэлэг <p>Сургалтын үйл ажиллагааны явцын үнэлгээний тайлан, зөвлөмжийг төвийн 2019 оны 411, 687, 688, 517, 519, 728, 808, 895, 896 тоот албан бичгээр сургалт эрхлэх байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын тайланг сургалт эрхлэх 4 байгууллага ирүүлсэн.</p>
<p style="text-align: center;"><i>2-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах болон тасралтгүй сургалтын багц хэрэглэгдэхүүн боловсруулах</p>	<p>1. 2019 онд Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургагч багшийн тоог “Эрүүл мэндийн ажилтны 2019-2020 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, хяналтын тоо, сургалтын хөтөлбөрийн жагсаалт, эмнэл зүйн сургагч багшийн төлөвлөгөө, сургалтын зардал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/121 дугаар тушаалаар батлуулсан. 2019 онд зохион байгуулагдах Эмнэл зүйн сургагч багшийн сургалтын удирдамж, төсвийн төсөл боловсруулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/51 дугаар тушаалаар баталгаажуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын тушаалаар Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалтыг 10 удаа зохион байгууллаа. Сургалтад эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэгч 20 байгууллагын нийт 240 эмч, сувилагч хамрагдан Эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэгдлээ. - Эмнэл зүйн Чиглүүлэгч багш бэлтгэх сургалтыг 1 удаа зохион байгуулж 16 эмч, 8 сувилагч чиглүүлэгч багшаар бэлтгэгдлээ. <p>2. ЭМХТ, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Анхан болон хоёр дахь шатлалын төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах нь” төслийн хүрээнд яаралтай тусламжийн чиглэлээр амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгөх, амилуулах лавшруулсан тусламжийн арга техникийг эзэмшүүлэх (Advanced Assessment for Life Support - AALS) сургалт зохион байгууллаа. Сургалтыг Япон улсад зохион байгуулагддаг AALS сургалтын хөтөлбөрөөр ЭМХТ-ийн захирлын баталсан удирдамжийн хүрээнд 10 удаагийн сургалт зохион байгуулагдаж нийт нийслэл, орон нутгийн яаралтай тусламжийн 80 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж сургагч багш бэлтгэгдлээ.</p>

	<p>3. Тусгай багаж хэрэгсэл ашиглахгүй, зүрх уушигны сэхээн амьдруулах тусламж үйлчилгээг үзүүлэх арга техникийг эзэмшүүлэх Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэгч /PBLs/” сургалт зохион байгууллаа. ЭМХТ-ийн захирлын А/44, А/74, А/91, А/176, А/183, А/191 А/193 тушаалаар “Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэгч /PBLs/” сургалтыг 16 удаа зохион байгуулж, нийт 156 яаралтай тусламжийн эмч нар хамрагдсан. Сургалтын өмнөх болон дараах сорилыг харьцуулахад эмч амилуулах тусламжийн мэдлэг 30-40 хувиар дээшилсэн.</p> <p>4. Эмнэлгийн мэргэжилтний халдварын сэргийлэлт, хяналтын талаархи мэдлэгийг дээшлүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээ сайжруулах зорилгоор “Эмнэлгийн мэргэжилтний халдварын сэргийлэлт , хяналт” сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандат судалгааны албан Эмнэлгээс шалтгаалах халдварын тасгийн эрхлэгч, Ж.Нямсүрэн, тархвар судлаач Г.Нарантуяа, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тархвар судлагч эмч Д.Насанцогт нар чиглүүлэн зохион байгуулсан. Сургалт ЭМХТ-ийн Ерөнхий захирлын баталсан хөтөлбөрийн дагуу 10 удаа танхимын болон ажлын байрны сургалтын хэлбэрээр зохион байгуулж аймаг нийслэлийн нийт 72 эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.</p> <p>5. Төслийн хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага ёс зүйн өнөөгийн байдалд үнэлгээ хийлгэж, эмнэлгийн мэргэжилтэн ба үйлчлүүлэгчдээс судалгаа авч сургалтын агуулга, хэрэгцээг тодорхойлон мөрдвөл зохих ёс зүйн үндсэн 5 зарчмыг боловсруулсан. Тус төв нь Японы олон улсын хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллага, Монголын сувилагчдын нийгэмлэгтэй хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сургалтыг 8 удаа зохион байгуулсан. Уг сургалтанд нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа 9 дүүрэг, төв болон тусгай мэргэжлийн төвийн нийт 300 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</p> <p>Цаашдаа Халдвар хамгааалал, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, амилуулах лавшруулсан тусламжийн арга техникийг эзэмшүүлэх, Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэгчийн сургалтыуудыг Резидент эмчийн баримжаа олгох сургалтанд оруулахаар төлөвлөсөн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p>	<p>1. Ерөнхий мэргэшил судлал Үндсэн мэргэшлийн сургалтанд нэмэлт элсэлт авах зорилгоор Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн шалгалтанд тэнцсэн боловч хуваарьт багтаж чадаагүй нийт эмч нартай холбогдон Эрүүл мэндийн яам, Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 10 дугаар</p>

	Загвар аймагт яаралтай тусламж, хүүхэд зэрэг сонгосон чиглэлээр багц цагийн сургалт зохион байгуулах, дээд шатлалын эрүүл мэндийн байгууллага нь дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагыг удирдан чиглүүлж ажиллах шаталсан тогтолцоог бий болгох	сарын 3-ны өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хурлын танхимд Ерөнхий мэргэшил судлал Үндсэн мэргэшлийн сургалтын талаар мэдээлэл хийсэн. 2019-2020 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалтанд нийт 24 элсэгч элсэн орсон. 2. Ерөнхий мэргэшил судлал Үндсэн мэргэшлийн сургалтын Яаралтай тусламж судлал тойролтын гарын авлага боловсруулах зорилгоор: Чингэлтэй дүүргийн ЭМТ, Орхон аймгийн БОЭТ-д богино хугацааны мэргэжилтэн ирж ажиллан Яаралтай тусламж судлал, Яаралтай тусламжийн гардан үйлдлийн гарын авлагын төслийн боловсруулан бэлэн болгож хянах шатанд явагдаж байна. 3. Загвар аймаг, дүүргийн эмнэлгийн эмнэл зүйн сургагч багш нарыг чадавхижуулах зорилгоор мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.				
7	<i>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</i> Төсөл амжилттай хэрэгжиж байна.	Ололттой тал: 2019 оны төлөвлөлтөд ороогүй ч боловч дараах ажлуудыг хамтран гүйцэтгэсэн. - Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр тавигдах дэлгэрэнгүй шаардлага боловсруулах арга зүйгээр ханган ажилласан. - “Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй” шаталсан сургалт зохион байгуулахад техникийн дэмжлэг үзүүлэн ажилласанаар мэргэшүүлэх сургалтын чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах нөхцөл бүрдсэн. - Сувилахуйн эмнэл зүйн сургагч багш бэлтгэх хөтөлбөр боловсруулж, сургал явуулахад арга зүйн зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн.				
8	<i>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх</i>	<i>Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ</i>				
9	<i>Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт</i>	<i>Биелэлтийн дундаж</i> 93.3%	<i>Зорилтын тоо</i> 3	<i>Зорилт 1</i> 100%	<i>Зорилт 2</i> 100%	<i>Зорилт 3</i> 85%
10	<i>Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ/</i>					

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ